



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох,  
түдгэлзүүлэх, арга хэмжээ авах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, 10.1.5 дах заалт, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн дугаар 08 хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүй Аюурвед энх, Сэцэн, Өлзийдөл, Вайбан зэрэг байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тусгай зөвшөөрөл авсан чиг үүргийнхээ дагуу болон албан ёсны хаяг дээрээ үйл ажиллагаа явуулаагүй, тодорхой ажлын байргүй Монмекс, Эрхэмсэг гоо, Сүлжээ, Киль туул ХХК, үйл ажиллагаа явуулж байгаа боловч хяналт шалгалтанд хамрагдаж хангалтгүй үнэлгээ авсан Өнөд Орших мөрөн зэрэг байгууллагуудын тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

3. Хяналт үнэлгээний дүнгээр шалгуур үзүүлэлтийн 70-аас доош хувийг хангаж байгаа хавсралтад дурьдсан байгууллагуудад ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг албан бичгээр мэдэгдэх арга хэмжээ авахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

4. Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, ханган нийлүүлэх, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох, байгууллагуудад тавигдах шаардлагын стандартыг боловсруулж, батлуулж, мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/ нарт даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-т даалгасугай.



САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080059

Эрүүл мэнд, спортын сайдын  
2014 оны 12 сарын 25 өдрийн  
14 дугаар тушаалын хавсралт

АЖИЛ САЙЖРУУЛАХ ХУГАЦААТАЙ ҮҮРЭГ ДААЛГАВАР  
АЛБАН БИЧГЭЭР МЭДЭГДЭХ БАЙГУУЛЛАГЫН НЭРС

| №  | Байгууллагын нэр     | Үйл ажиллагааны нэр  |
|----|----------------------|--|
| 1  | Стандлаб ХХК         | Эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношлуур импортлох, ханган нийлүүлэх                           |
| 2  | Бадруун Энх ХХК      | Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, протез, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх |
| 3  | Нуган трейд ХХК      | Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх                                    |
| 4  | Эндожен Монголиа ХХК | Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж /хиймэл үе, протез/ импортлох, ханган нийлүүлэх                    |
| 5  | Нарт эрдэнэс ХХК     | Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх  |
| 6  | Эс Икс Би ХХК        | Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх  |
| 7  | Глобал пиларс ХХК    | Эмнэлгийн багаж, протез, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх                                   |
| 8  | Мон орто мед ХХК     | Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх  |
| 9  | Шинжьюку ХХК         | Эмнэлгийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх                               |
| 10 | Супер проб ХХК       | Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх   |